



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Содномын ЧИНЗОРИГ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-52-06, Факс: 32-70-16  
E-mail: secretariat@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2022.10.12 № УИХ-03/9424  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

С.ЧИНЗОРИГ  
Д.ТОГТОХСҮРЭН  
Н.ЭНХБОЛД  
Г.ГАНБОЛД  
Ж.БАТЖАРГАЛ  
Н.НАРАНБААТАР  
Т.ЭНХТҮВШИН  
Д.БАТЛУТ  
Ц.ИДЭРБАТ

000047



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Содномын ЧИНЗОРИГ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-52-06, Факс: 32-70-16  
E-mail: secretariat@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2022.08.24 № УИХ-03/4893  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т


Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тов  
тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн 26.1, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан бүрэн эрхийнхээ дагуу Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу Засгийн газраас санал, дүгнэлт авахаар хүргүүлсэн. Засгийн газраас хуулийн төслийг хэлэлцсэн хуралдааны тэмдэглэлийг ирүүлсэн тул хуулийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлал, хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, зардлын тооцоо зэргийг хавсаргав.

Хавсралт 39. хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  С.ЧИНЗОРИГ





МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 <sup>22</sup> он <sup>08</sup> дугаар  
сарын <sup>08</sup>-ны өдөр

Дугаар *ХТТ/1807*

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
С.ЧИНЗОРИГ ТАНАА

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Та бүхний санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



*Ц.НЯМДОРЖ*

000225009877

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлд:

“III.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын санаачлан боловсруулсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын санаачлан боловсруулсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараахь саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1. Төрийн албаны тухай хуулиар төрийн захиргааны албан хаагч нь албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал авахаар зохицуулсан. Мөн төрийн захиргааны албан хаагч Төрийн албаны тухай хуулиар тогтоосон тусламж, нөхөн олговор, тусгайлсан нийтлэг болон нэмэгдэл баталгаагаар хангагдахаар хуульд заажээ.

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэн цагаас хойш төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг зохицуулсан 30 гаруй хууль, тогтоомж батлагдсаны дотор төрийн албан хаагчийн цалин хөлсийг аль болох олон төрлийн нэмэгдэл, урамшуулалтай болгох, тэтгэмж олгох замаар нэмэгдүүлж, салбар бүрт хэт ялгаатай цалин хөлс олгогдох нөхцөл байдлыг бий болгосон зарим сөрөг үр дагавар үүсэж байна. Тухайлбал, төрийн албан хаагчид үндсэн цалингаас нь тооцож дунджаар сар тутам 30-75 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл, мөн ажлын үр дүнгээр улирал тутамд 40 хүртэл хувийн мөнгөн урамшуулал олгодог зөрүүтэй зохицуулалт үйлчилж байна.


Иймд хуулийн төсөл нь Төрийн албаны тухай хуулийн 7.1.4-т заасан “Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах” гэсэн суурь зарчимтай нийцэхгүй, ийнхүү эрхэлж байгаа албан тушаалын байдлаар нь тусгайлан хуульчлах нь Төрийн албаны тухай хуулиар зохицуулах харилцааны хүрээг хумих, харилцан уялдааг алдагдуулах сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй байгааг анхаарах;

2. Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, сумын Засаг даргын тамгын газрын мэргэжилтний албан тушаалыг нэг зэрэглэлээр ахиулж үндсэн цалингийн хэмжээг 5.2 хувиар нэмэгдүүлсэн.

Түүнчлэн Засгийн газрын зүгээс аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг дээшлүүлэх хүрээнд орон нутгийн нэмэгдлийг сар бүр олгодог байх эрх зүйн орчинг бүрдүүлэхээр төлөвлөж, холбогдох тооцоо судалгааг хийж байна.

Ийнхүү төрийн албан хаагчдад сар бүрийн цалин дээр тогтмол олгох нэмэгдэл нь нэг удаагийн шинжтэй мөнгөн урамшуулал, тэтгэмжээс илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Иймд хуулийн төсөлд тусгасан асуудлыг төрийн албаны цалин хөлсний тогтолцооны шинэчлэл хийх үеэр нэг мөр авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
С. ЧИНЗОРИГ

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.

Уг хуулиар төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж байна.

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлээр төрийн албан хаагчийн цалин хөлстэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд 57.2.2-т төрийн захиргааны албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс бүрдэнэ гэж заасан байдаг.

Сумын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид дунджаар 690.0 мянга орчим төгрөгийн үндсэн цалин, ажилласан жилээс хамаарч дунджаар үндсэн цалингийн 35 орчим хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл авдаг. Харин шинээр ажилд орж байгаа албан хаагч 615.0 төгрөгийн үндсэн цалинтай байх бөгөөд ямар нэгэн нэмэгдэл авах боломжгүй байдаг.

Түүнчлэн аймгийн төвөөс бусад сум, тосгон, багт ажиллаж нийгмийн суурь үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа боловсролын салбарын багш, эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтан болон төрийн тусгай албаны цагдаа, онцгой байдлын байгууллагын алба хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, цэргийн офицер, ахлагчид 5 жил тутам (тасралтгүй ажилласан)-д нэг удаа мөнгөн урамшууллыг салбар тус бүрийн хуулиар зохицуулан олгож байна.

Гэвч аймгийн төвөөс бусад сумын төвд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид дээр дурдсан мөнгөн урамшуулал олгох хууль эрх зүйн зохицуулалт байхгүй тул тус албан хаагчдын нийгмийн баталгаа дордох нөхцөл үүсээд байна.

**1.2.Практик шаардлага**

Аймгийн төвөөс бусад 309 сумын Засаг даргын тамгын газарт нийт 2487 орчим төрийн захиргааны албан хаагчид ажиллаж байна. Үүнээс тус байгууллагад тасралтгүй 1 жил ажиллаж байгаа 297, 2 жил ажиллаж байгаа 206, 3 жил ажиллаж байгаа 232, 4 жил ажиллаж байгаа 218, 5 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа 1534 албан хаагчид байна.

Их дээд сургууль төгсөөд сумын төвийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа багшийн үндсэн цалин 850.0 – 950.0 мянга төгрөг, эмнэлэгт эмчээр ажиллаж байгаа эмчийн үндсэн цалин 850.0 – 950.0 ажиллаж байгаа албан хаагч 840.0 – 940.0 мянга төгрөг байна. Харин их сургууль төгсөөд сумын төрийн захиргааны албанд ажиллаж байгаа албан хаагчийн үндсэн цалин 615.0 мянган төгрөг байна.

Мөн аймгийн төвөөс бусад сумын төвд ажиллаж байгаа эмч, багш нар болон зарим төрийн үйлчилгээний албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 5 жил тутам (тасралтгүй ажилласан)-д нэг удаа мөнгөн урамшуулал олгож байна.

Аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид тасралтгүй, тогтвор суурьшилтай ажилласны урамшуулал олгох хууль, эрх зүйн орчин зохицуулалт байхгүйн улмаас сумын төрийн захиргааны байгууллагууд хүний нөөцийн дутагдалд орох, албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байх нөхцөл үүсэх, сумд ажиллах албан хаагчдын тоо жил бүр буурч байна.

Иймд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмж тусгах хуулийн төслийг боловсрууллаа.

### **Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасныг үндэслэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөл нь аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газрын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор тасралтгүй ажилласан таван жил тутамд нэг удаа мөнгөн урамшуулал олгох харилцааг зохицуулна.

Хуулийн төсөл нь дараах гурван зүйлтэй байна. Үүнд:

Хуулийн төслийн Нэгдүгээр зүйлд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн байгууллагаас олгох;

Хуулийн төслийн Хоёрдугаар зүйлд уг мөнгөн урамшууллыг олгох журмыг Засгийн газар батлах;

Хуулийн төслийн Гуравдугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тогтоох зохицуулалтыг тус тус тусгана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэх, нийгмийн баталгаа нь дээшлэх, амьдралын нөхцөл, чанараа сайжруулахад нь тодорхой санхүүгийн дэмжлэг болох юм. Мөн сумын захиргааны байгууллагын хүний нөөцийн чадавхи бэхжинэ.

Хуулийн төсөл батлагдсанаар эхний жилд дунджаар 1534 хүнд 5.0 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгогдох ба цаашид энэ урамшуулалд жилд дунджаар 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдана. Уг зардлын эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

**Дөрөв. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар**

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор шинэ хуулийн төсөл боловсруулах, бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

---oOo---



## ТАНИЛЦУУЛГА

*Сумын Засаг даргын Тамгын газрын  
төрийн жинхэнэ албан хаагчид  
мөнгөн урамшуулал олгох тухай*

Аймгийн төвөөс бусад сум, тосгон, багт ажиллаж нийгмийн суурь үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа боловсролын салбарын багш, эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтан болон төрийн тусгай албаны цагдаа, онцгой байдлын байгууллагын алба хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, цэргийн офицер, ахлагчид 5 жил тутам (тасралтгүй ажилласан)-д нэг удаа мөнгөн урамшууллыг олгож байна.

Аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид тасралтгүй, тогтвор суурьшилтай ажилласны урамшуулал олгох хууль, эрх зүйн орчин зохицуулалт байхгүйн улмаас сумын төрийн захиргааны байгууллагууд хүний нөөцийн дутагдалд орох, албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байх нөхцөл үүсээд байна. Тухайлбал, их сургууль төгсөөд сумын төвийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа багшийн үндсэн цалин 850.0 – 950.0 мянга төгрөг, эмнэлэгт эмчээр ажиллаж байгаа эмчийн үндсэн цалин 850.0 – 950.0 ажиллаж байгаа албан хаагч 840.0 – 940.0 мянга төгрөг байна. Харин сумын төрийн захиргааны албанд ажиллаж байгаа албан хаагчийн үндсэн цалин 615.0 мянган төгрөг байна. Цалин хөлс бага, нийгмийн баталгаа сул байгаагаас шалтгаалан сумын засаг даргын тамгын газарт мэргэжилтэнээр орж ажиллах залуучуудын сонирхол туйлын бага байна. Тухайлвал улсын хэмжээгээр сумдын засаг даргын тамгын газарт 1338 орон тоо сул байгаагаас 854 мэргэжилтэн өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөлөгдсөн 319 мэргэжилтэн өөр ажилд шилжсэн байна.

Сумын засаг даргын тамгын газрууд 1089 сул орон тооны захиалга Төрийн албаны салбар зөвлөлүүдэд хүргүүлсэн боловч 499 сул орон тоонд нөөцөд бүртгүүлсэн иргэн байхгүй 413 сул орон тоонд иргэн бүртгүүлээгүйн улмаас сул орон тоо нөхөгдөж чадаагүй байна.

Иймд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмж тусгах хуулийн төслийг боловсрууллаа.

Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт нийт 2487 орчим төрийн захиргааны албан хаагчид ажиллаж байна. Үүнээс тус байгууллагад тасралтгүй 1 жил ажиллаж байгаа 297, 2 жил ажиллаж байгаа 206, 3 жил ажиллаж байгаа 232, 4 жил ажиллаж байгаа 218, 5 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа 1534 албан хаагчид байна.

Хуулийн төсөл батлагдсанаар сумдад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэж амьдралын нөхцөл, чанараа дээшлүүлэхэд нь тодорхой санхүүгийн дэмжлэг болох бөгөөд 2023 онд 1534 хүнд олгох мөнгөн урамшуулалд 5.0 тэрбум төгрөг, цаашид жил бүр дунджаар 1.0 тэрбум төгрөг шаардагдана.

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... сарын ... өдөр

Дугаар ....

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.3 дахь хэсэг нэмсүгэй:

“51.3.Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2023 оны 01дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН ТАНДАН СУДАЛГАА**

**Улаанбаатар хот**

**2022 он**

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН  
ТАНДСАН ТУХАЙ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

**НЭГ.** Асуудлын дүн шинжилгээ

- 1.1. Тулгамдаж буй асуудал, түүний цар хүрээ, асуудлыг үүсгэж буй учир шалтгаан
- 1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

**ХОЁР.** Асуудлыг шийдвэрлэх зорилго

- 2.1. Гол зорилго, зорилт

**ГУРАВ.** Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт

- 3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд
- 3.2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулсан тухай
- 3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

**ДӨРӨВ.** Зохицуулалтын хувилбарын үр нөлөөний талаар

- 4.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
  - 4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
  - 4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
  - 4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө
  - 4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

- 4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

**ТАВ.** Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх

**ЗУРГАА.** Тухайн зохицуулалтын талаархи бусад хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан судалгаа

**ДОЛОО.** Дүгнэлт, зөвлөмж

## **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ**

### **1.1.Тулгамдаж буй асуудал, түүний цар хүрээ, асуудлыг үүсгэж буй учир шалтгаан**

Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт нийт 3400 орчим төрийн захиргааны албан хаагчид ажиллаж байна.

Сумын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид дунджаар 690.0 мянга орчим төгрөгийн үндсэн цалин, ажилласан жилээс хамаарч дунджаар үндсэн цалингийн 35 орчим хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл авдаг. Харин шинээр ажилд орж байгаа албан хаагч 615.0 төгрөгийн үндсэн цалинтай байх бөгөөд ямар нэгэн нэмэгдэл авах боломжгүй байдаг.

Их дээд сургууль төгсөөд сумын төвийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа багшийн үндсэн цалин 850.0 – 950.0 мянга төгрөг, эмнэлэгт эмчээр ажиллаж байгаа эмчийн үндсэн цалин 850.0 – 950.0 ажиллаж байгаа албан хаагч 840.0 – 940.0 мянга төгрөг байна. Харин их сургууль төгсөөд сумын төрийн захиргааны албанд ажиллаж байгаа албан хаагчийн үндсэн цалин 615.0 мянган төгрөг байна.

Түүнчлэн аймгийн төвөөс бусад сум, тосгон, багт ажиллаж нийгмийн суурь үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа боловсролын салбарын багш, эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтан болон төрийн тусгай албаны цагдаа, онцгой байдлын байгууллагын алба хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, цэргийн офицер, ахлагчид 5 жил тутам (тасралтгүй ажилласан)-д нэг удаа мөнгөн урамшууллыг салбар тус бүрийн хуулиар зохицуулан олгож байна.

Гэвч аймгийн төвөөс бусад сумын төвд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид дээр дурдсан мөнгөн урамшуулал олгох хууль эрх зүйн зохицуулалт байхгүй тул тус албан хаагчдын нийгмийн баталгаа дордох нөхцөл үүсээд байна.

Аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид тасралтгүй, тогтвор суурьшилтай ажилласны урамшуулал олгох хууль, эрх зүйн орчин зохицуулалт байхгүйн улмаас сумын төрийн захиргааны байгууллагууд хүний нөөцийн дутагдалд орох, албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байх нөхцөл үүсэх, сумд ажиллах албан хаагчдын тоо жил бүр буурч байна.

Иймд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

### **1.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд**

Аймгийн төвөөс бусад 309 сумын Засаг даргын тамгын газарт нийт 2487 орчим төрийн захиргааны албан хаагчид ажиллаж байна. Үүнээс тус байгууллагад тасралтгүй 1 жил ажиллаж байгаа 297, 2 жил ажиллаж байгаа 206, 3 жил ажиллаж

байгаа 232, 4 жил ажиллаж байгаа 218, 5 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа 1534 албан хаагчид байна.

## **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО**

### **2.1. Гол зорилго, зорилт**

Аймгийн төвөөс бусад сумын төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг нь дээшлүүлэх зорилгоор тасралтгүй ажилласан 5 жил тутамд нэг удаа мөнгөн урамшуулал олгох харилцааг зохицуулах шаардлагатай байна.

Иймд дээрх хууль зүйн үндэслэл болон практик шаардлагын дагуу Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл боловсруулав.

## **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ**

### **3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд**

#### **3.1.1. “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:**

Дээр тодорхойлсон асуудал нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид зохицуулалт байхгүйгээс үүдэн гарч байгаа тул “тэг” хувилбар оновчгүй нь илэрхий байна.

#### **3.1.2. Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх:**

Төрийн албан хаагчдын цалин хөлс, шагнал, урамшууллын асуудлыг холбогдох хуульд тусгасны үндсэн дээр хэрэгжүүлэх боломжтой байдаг тул уг асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ухуулга, сурталчилгаа хийх арга замаар асуудлыг шийдвэрлэж чадахгүй.

#### **3.1.3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх:**

Шийдвэрлэхийг зорьж буй асуудлууд нь татвар, хураамжийн бодлого, зөвшөөрөл, лиценз, квот олгохтой холбоогүй асуудлууд учир эдгээр эдийн засгийн хэрэгслүүдээр шийдвэрлэгдэх боломжгүй юм.

#### **3.1.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх:**

Төрөөс санхүүгийн интервенц хийх замаар дээрх асуудлуудыг шийдвэрлэх боломжгүй.

#### **3.1.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх:**

Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газрын төрийн захиргааны албан хаагчид нэг удаа мөнгөн урамшуулал олгох асуудал энэ хувилбараар шийдвэрлэгдэх боломжгүй юм.

#### 3.1.6. Захиргааны шийдвэр гаргах:

Төрийн албан хаагчдын цалин хөлс, шагнал, урамшуулал, тэтгэмжтэй холбоотой асуудлыг Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуульд тусгасны үндсэн дээр хэрэгжүүлэх боломжтой байдаг. Харин холбогдох хуульд цалин хөлс, шагнал, урамшуулал, тэтгэмжтэй холбоотой зохицуулалт тусгагдсаны дараа түүнийг олгох нөхцөл, шалгуур, хэрхэн олгох зохион байгуулалт зэргийг захиргааны акт, захиргааны хэм хэмжээний актаар шийдвэрлэх боломжтой.

Иймд дээр тодорхойлсон асуудлыг захиргааны хэм хэмжээний акт шинээр батлуулах байдлаар шийдвэрлэх боломжгүй байна.

#### 3.1.7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах:

Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаансарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох асуудлыг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх бүрэн боломжтой.

Дээрх хувилбаруудыг нягталж үзэхэд “Тэг” хувилбар, Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх хувилбар, Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх хувилбар, Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар, Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх, Захиргааны шийдвэр гаргах хувилбарууд үр дүнгүй болох нь харагдлаа.

*Иймд асуудлыг Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл боловсруулах хувилбараар шийдвэрлэхээр тогтов.*

### **3.2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулсан тухай**

Тухайн асуудлыг зөвхөн “хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар”- аар шийдвэрлэх тул зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулах харьцуулалт хийх шаардлагагүй.

### **3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай**

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгон аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх нь хамгийн оновчтой, үр дүнтэй арга юм.

Иймд Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл дараах бүтэцтэйгээр боловсруулна. Үүнд:

- Хуулийн огноо, дугаар, газар;
- Хуулийн нэр;
- Хуулийн тогтоох хэсэг;
- Хууль хүчин төгөлдөр болох хугацааг заасан хэсэг.

## ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨНИЙ ТАЛААР

### 4.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон 1 хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

*Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хавсралт хэсгийн хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.*

#### 4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Тандан судалгааны явцад сонгосон “Хуулийн төсөл боловсруулах” зохицуулалтын хувилбарын хүрээнд хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

### ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

*Хүснэгт 1*

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад эрх тэгш байдлыг бий болгоно.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагч бүрийн нийгмийн баталгааг сайжруулах боломжтой.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагч бүрийн нийгмийн баталгааг сайжруулж байгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн	Тийм	Хууль тогтоомжийн төсөл нь аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад ижил тэгш үйлчлэх зарчим дээр үндэслэх тул тухайн албан



	оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх			хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, амьдралын нөхцөл, чанараа дээшлүүлэхэд нь тодорхой санхүүгийн дэмжлэг болох, нийгмийн баталгааг дээшлүүлэх зэрэг асуудлууд хөндөгдсөн бөгөөд эдгээр зохицуулалтууд нь олон улсын болон үндэсний хэм хэмжээнд нийцсэн байна.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Хуулийн төсөл батлагдсанаар аливаа иргэн, хуулийн этгээдэд ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлэх, үзүүлж болзошгүй нөхцөл байдал бий болохгүй юм.
1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Хуулийн төсөлд ямар нэгэн ялгаварлан гадуурхах, давуу байдлыг бий болгох зохицуулалт тусгагдаагүй. Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын нийгмийн баталгаа дээшлэх боломжийг бий болгох юм.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Хуулиар хүний эрхийг хязгаарлахгүй.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	Ийм зохицуулалт оруулах шаардлагагүй.
2.Хүний эрхийг хязгаарла сан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		Үгүй	Хүний эрхийг хязгаарлахгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		Ямар нэг сөрөг нөлөөгүй.

	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Ийм зохицуулалт оруулах шаардлагагүй.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын нийгмийн баталгаа дээшилнэ.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)		Үгүй	Ийм зохицуулалт оруулах шаардлагагүй.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		Монгол Улсын Засгийн газар, холбогдох сум, орон нутагт тасралтгүй ажиллаж байгаа Засаг даргын тамгын газрын албан хаагчдын нийгмийн асуудлуудыг хуулиар тогтоох харилцаанд үүрэг хүлээх ба эдгээрийн хүлээх үүргийг тодорхой тусгана.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Хүйсээр ялгаварлахыг хориглох агуулга хүний эрхийн ерөнхий зарчмын хүрээнд тусгагдана.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Сум, орон нутагт тасралтгүй ажиллаж байгаа Засаг даргын тамгын газрын албан хаагчдыг хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

#### 4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

“Хуулийн төсөл боловсруулах” хувилбар нь дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж байгууллагад эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй нь Аргачлалын 6.2-т заасан эдийн засагт үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариултаас харагдаж байна. Харин аймгийн төвөөс бусад сумдын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэж амьдралын нөхцөл, чанараа дээшлүүлэхэд нь тодорхой санхүүгийн дэмжлэг болох бөгөөд 2023 онд 1534 хүнд олгох мөнгөн урамшуулалд 5.0 тэрбум төгрөг, цаашид жил бүр дунджаар 1.0 тэрбум төгрөг шаардагдана.

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 2

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуудлууд	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Үгүй	Аж ахуй нэгжид шинээр зардал үүсэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Үгүй	Хуулийн этгээдээс нэмэлт хөрөнгө шаардахгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
6.Инноваци болон	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.

судалгаа шинжилгээ	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Аймгийн төвөөс бусад сумдын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын гэр бүлийн төсөвт дунд, урт хугацаанд санхүүгийн эерэг нөлөө үзүүлнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

#### 4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

“Хуулийн төсөл боловсруулах” хувилбар нь Аргачлалын 6.2-т заасан нийгэмд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариултаас харагдаж байгаа бөгөөд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн

захиргааны албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэх, нийгмийн баталгаа нь дээшлэх, амьдралын нөхцөл, чанараа сайжруулахад нь тодорхой санхүүгийн дэмжлэг болох юм. Мөн сумын захиргааны байгууллагын хүний нөөцийн чадавхи бэхжинэ.

### НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 3

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Төрийн захиргааны албан хаагчид суманд тогтвор суурьшилтай ажиллахад эерэг нөлөө үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Их дээд сургууль дөнгөж төгссөн мэргэжилтнүүд сумын төрийн захиргааны албанд тогтвор суурьшилтай ажиллахад эерэг нөлөө үзүүлнэ.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид уг мөнгөн урамшууллыг эрүүл мэндээ сайжруулахад зарцуулах боломжтой.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид бүгд хамрагдах боломжтой.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг,		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.

	хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт			
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Монгол Улсын Засгийн газар, холбогдох сум, орон нутагт тасралтгүй ажиллаж байгаа Засаг даргын тамгын газрын албан хаагчдын нийгмийн асуудлуудыг хуулиар тогтоох харилцаанд үүрэг хүлээх ба эдгээрийн хүлээх үүргийг тодорхой тусгана.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм		Монгол Улсын Засгийн газар, холбогдох сум, орон нутагт тасралтгүй ажиллаж байгаа Засаг даргын тамгын газрын албан хаагчдын нийгмийн асуудлуудыг хуулиар тогтоох харилцаанд үүрэг хүлээх ба эдгээрийн хүлээх үүргийг тодорхой тусгана.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй
5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх			Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх			Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
6.Нийгмийн хамгаалал,	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар,		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.

эрүүл мэнд, боловсролын систем	хүртээмжид нөлөөлөх эсэх			
	6.2.Ажилчдын боловсрол, хөдөлгөөнд шилжилт нөлөөлөх эсэх	Тийм		Төрийн захиргааны албан хаагчид суманд тогтвор суурьшилтай ажиллахад эерэг нөлөө үзүүлнэ.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид уг мөнгөн урамшууллыг эрүүл мэндээ сайжруулахад зарцуулах боломжтой.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Энэ асуудалтай холбоогүй.

#### 4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Аргачлалын 6.2-т заасан байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариултаас харагдахад “Хуулийн төсөл боловсруулах” хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна.

### БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 4

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.



	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
7.Нөхөн сэргээгдэх /нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.

#### 4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Уг хуулийн төсөлтэй уялдуулан шинэ хууль боловсруулах, бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

#### ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ ХИЙХ

Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа мөнгөн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхэд боломжит тэг хувилбар, сурталчилгааны ажил өрнүүлэх хувилбар, эдийн засгийн хэрэгслийг ашиглах хувилбар, санхүүгийн интервенц хийх хувилбар, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хувилбар, захиргааны шийдвэр гаргах хувилбар, хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбаруудаас **хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар** нь хамгийн үр дүнтэй болох нь харагдлаа.

Энэхүү тандан судалгаагаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг нарийвчлан судалж, хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг дэлгэрэнгүй судалсан болно.

- Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг судалж үзэхэд:
  - Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх нөхцөлийг бүрэн хангасан;
  - Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулахгүй;
  - Тодорхой эрх бүхий этгээдүүдийн ялгаатай хэрэгцээг тооцсон зохицуулалтыг тусгасан;
  - Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцсэн болох нь харагдаж байна.
- Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний хувьд уг хувилбар нь улсын төсөвт тодорхой хэмжээний нэмэлт зардал гарна. Харин аж ахуй нэгж, иргэнээс нэмэлт зардал шаардахгүй бөгөөд эдийн засагт сөрөг нөлөө байхгүй.
- Нийгэмд үзүүлэх үр нөлөөг судалж үзэхэд нийгмийн тодорхой бүлэг буюу аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй

ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид эерэг нөлөө үзүүлэх нь харагдаж байна.

- Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний хувьд эерэг болон сөрөг нөлөө байхгүй болно.

## **ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.

Уг хуулиар төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж байна.

Аймгийн төвөөс бусад сум, тосгон, багт ажиллаж нийгмийн суурь үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа боловсролын салбарын багш, эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтан болон төрийн тусгай албаны цагдаа, онцгой байдлын байгууллагын алба хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, цэргийн офицер, ахлагчид 5 жил тутам (тасралтгүй ажилласан)-д нэг удаа мөнгөн урамшууллыг салбар тус бүрийн хуулиар зохицуулан олгож байна.

Гэвч аймгийн төвөөс бусад сумын төвд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид дээр дурдсан мөнгөн урамшуулал олгох хууль эрх зүйн зохицуулалт байхгүй тул тус албан хаагчдын нийгмийн баталгаа дордох нөхцөл үүсээд байна.

### **ДОЛОО. ЗӨВЛӨМЖ**

Аймгийн төвөөс бусад сумын төвд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх хамгийн зохистой шийдлийг олох зорилгоор урьдчилан тандан судлах судалгааг хийсний үндсэн дээр Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулах замаар асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжтой гэж дүгнэн дараах асуудлыг тусгасан хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэсэн санал бүхий зөвлөмжийг Аргачлалын 9-д заасны дагуу боловсрууллаа. Үүнд:

1.Холбогдох албан хаагчид мөнгөн урамшуулал олгох хуулийн төсөл боловсруулах;

2.Нийгмийн суурь үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа боловсролын салбарын багш, эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтан болон төрийн тусгай албаны цагдаа, онцгой байдлын байгууллагын алба хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, цэргийн офицер, ахлагчид 5 жил тутам (тасралтгүй ажилласан)-д нэг удаа мөнгөн урамшуулал олгож байгаатай адилаар аймгийн төвөөс бусад сумын төвд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор тасралтгүй ажилласан таван жил

тутамд нэг удаа мөнгөн урамшуулал олгодог байхаар хуулийн төсөлд тусгах зэрэг болно.

---oOo---

Урьдчилсан гэрээний үндсэн дээр 2015 оны 12 сарын 31-ний өдөр төсөлд тусгах зэрэг болно.

---

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ  
ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2022 он

**ТӨРӨӨС ОЛГОХ НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭ  
ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

**Гарчиг**

**НЭГ.** Ерөнхий зүйл

**ХОЁР.** Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

**ГУРАВ.** Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

**ДӨРӨВ.** Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.4. “Зардал тооцох” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

4.5. “Харилцан уялдааг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

**ТАВ.** Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

5.1. Баримтжуулалт

5.2. Дүгнэлт

5.3. Зөвлөмж

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн /цаашид “ХТТХ” гэх/ 12.1.2 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсны үндсэн дээр “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг сонгон авч, тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулан баталсан.

Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан бөгөөд тус тогтоолын төсөл батлагдан хэрэгжсэнээр хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ямар үр дагавар, үр нөлөө үзүүлэхийг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, харилцан уялдааг тогтоох, тогтоолын төслийг ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдөх, практикт хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.3 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу тогтоолын төслийн үр нөлөөг үнэллээ.

“Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төслийг дараах үе шаттайгаар хийлээ.

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

### ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тогтоолын төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан доорх 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Зардал тооцох;
5. Харилцан уялдаа.

**“Зорилгод хүрэх байдал”:** Хуулийн төсөлд туссан зүйлүүд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж чадах эсэх; тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх; хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тооцох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

**“Ойлгомжтой байдал”:** Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн /аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид, Монгол Улсын Засгийн газар, сумдын Засаг даргын тамгын газар/ хувьд ойлгомжтой байгаа эсэх; хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай эсэх; агуулга, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгомжтой эсэхийг тогтоох зорилгоор энэ шалгуур үзүүлэлтийг сонголоо.

**“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”:** Хуулийн үр дагаварт шууд хамаарах субъектүүд /аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид, Монгол Улсын Засгийн газар, сумдын Засаг даргын тамгын газар/ хуулийн төслийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

**“Зардал тооцох”:** Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал гарах эсэхийг үнэлэх зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонголоо.

**“Харилцан уялдаа”:** Хуулийн төслийн зүйлүүд бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцэж байгаа, эсхүл зөрчилдөж байгаа эсэхэд үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэж тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

### **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараахь байдлаар тогтоолоо.

*Хүснэгт 1*

<b>Д/д</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хэсэг</b>	<b>Шалгах хэрэгсэл</b>
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл.	Хуулийн төслийн 2 зүйл нь тавьсан зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдож чадсан эсэх, тогтоолын төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах.	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.1 дэх хэсэгт заасан аргачлалын 5 дугаар бүлэгт нийцсэн эсэхийг шалгах.
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах.	Хуулийг хэрэгжүүлэх байгууллага /Монгол Улсын Засгийн газар, сумдын Засаг даргын тамгын газар/ хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах.
4	Зардал тооцох	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл.	Хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардах эсэх; иргэн, хуулийн этгээд нэмэлт зардал гарах эсэхийг шалгах.
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах.	“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-д заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах.

**ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН  
ДАГУУ ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Энэ тайлангийн 3 дугаар бүлэгт сонгосон хэсгүүдэд дээрх шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд дараах байдлаар үнэлгээ хийлээ.

**4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлээр төрийн албан хаагчийн цалин хөлстэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд 57.2.2-т төрийн захиргааны албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс бүрдэнэ гэж заасан байдаг.

Сумын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид дунджаар 690.0 мянга орчим төгрөгийн үндсэн цалин, ажилласан жилээс хамаарч дунджаар үндсэн цалингийн 35 орчим хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл авдаг бол шинээр ажилд орж байгаа албан хаагч 615.0 төгрөгийн үндсэн цалинтай байх бөгөөд ямар нэгэн нэмэгдэл авах боломжгүй байдаг.

Их дээд сургууль төгсөөд сумын төвийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа багшийн үндсэн цалин 850.0 – 950.0 мянга төгрөг, эмнэлэгт эмчээр ажиллаж байгаа эмчийн үндсэн цалин 850.0 – 950.0 ажиллаж байгаа албан хаагч 840.0 – 940.0 мянга төгрөг байна.

Түүнчлэн аймгийн төвөөс бусад сум, тосгон, багт ажиллаж нийгмийн суурь үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа боловсролын салбарын багш, эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтан болон төрийн тусгай албаны цагдаа, онцгой байдлын байгууллагын алба хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, цэргийн офицер, ахлагчид 5 жил тутам (тасралтгүй ажилласан)-д нэг удаа мөнгөн урамшууллыг салбар тус бүрийн хуулиар зохицуулан олгож байна.

Гэвч аймгийн төвөөс бусад сумын төвд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид дээр дурдсан мөнгөн урамшуулал олгох хууль эрх зүйн зохицуулалт байхгүй тул тус албан хаагчдын нийгмийн баталгаа дордох нөхцөл үүсээд байна.

Аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид тасралтгүй, тогтвор суурьшилтай ажилласны урамшуулал олгох хууль, эрх зүйн орчин зохицуулалт байхгүйн улмаас сумын төрийн захиргааны байгууллагууд хүний нөөцийн дутагдалд орох, албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байх нөхцөл үүсэх, сумд ажиллах албан хаагчдын тоо жил бүр буурч байна.

Иймд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.



**Зорилт 1:** Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох.

**Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд**

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлд “51.3.Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн байгууллагаас нь олгоно.” гэсэн хэсэг нэмсүгэй.

**Зорилгод хүрч байгаа эсэх талаар:**

“Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл Зорилт 1-ийг бүрэн хангаж байна.

**Зорилт 2:** Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох нөхцөл, журмыг Засгийн газар тогтоох.

**Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд**

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлд “51.4.Энэ хуулийн 51.3-д заасан мөнгөн урамшууллыг олгох нөхцөл, журмыг Засгийн газар тогтооно.” гэсэн хэсэг нэмсүгэй.

**Зорилгод хүрч байгаа эсэх талаар:**

“Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл Зорилт 2-ыг бүрэн хангаж байна.

**4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.1 дэх хэсэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын Тавдугаар бүлэг “Хуулийн төсөл боловсруулах”-т заасан шаардлагыг дараах байдлаар хангаж байна.

Хүснэгт 4

<b>Хуулийн төсөлд тавигдах шаардлага</b>		
1	Үндсэн хууль, бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний заалттай нийцсэн байх;	Уг шаардлагыг хангасан.
2	Хууль, тогтоолын заалтыг давтахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
3	Хоёрдмол утга агуулаагүй, ойлгомжтой байх;	Уг шаардлагыг хангасан.
4	Хариуцлагын хэм хэмжээг заахгүй байх.	Уг шаардлагыг хангасан.
<b>Хуулийн төслийн бүтцэд тавигдах шаардлага</b>		
5	Хуулийн төслийн гарчиг;	<b>“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”</b>
6	Шаардлагатай тохиолдолд тэмдэглэх хэсэг;	-
7	Тогтоох хэсэг;	<b>1 дүгээр зүйл.</b> Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.3, 51.4 дэх хэсэг нэмсүгэй: “51.3.Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн байгууллагаас нь олгоно. 51.4.Энэ хуулийн 51.3-д заасан мөнгөн урамшууллыг олгох нөхцөл, журмыг Засгийн газар тогтооно.”
8	Шаардлагатай тохиолдолд урьд гарсан шийдвэрийг хүчингүй болсонд тооцох тухай хэсэг;	-
9	Шаардлагатай бол тогтоол хүчин төгөлдөр болох хугацаа.	<b>2 дугаар зүйл.</b> Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**4.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект Монгол Улсын Засгийн газар, сумдын Засаг даргын тамгын газар болон аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид юм.

Хуулийн төсөлд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгож тэдгээрийн нийгмийн баталгааг дээшлүүлэх асуудлыг тусгасан тул холбогдох байгууллагууд болон албан хаагчид тус хуулийн төслийг хүлээн зөвшөөрнө.

#### **4.4. “Зардлыг тооцох” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр улсын төсвөөс 2023 онд 5.0 тэрбум төгрөг, 2024 онд 1.0 тэрбум төгрөг, 2025 онд 1.0 тэрбум төгрөг, 2026 онд 1.0 тэрбум төгрөг, 2027 онд 1.0 тэрбум 200 сая төгрөг зарцуулагдахаар байна. Аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт хөрөнгийн дарамт үүсгэхгүй болно.

Харин аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын санхүү байдалд эерэг нөлөөтэй байна.

#### **4.5. “Харилцан уялдааг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараахь стандарт асуултад хариулах замаар тогтоолын төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

Ингэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуульд нийцсэн эсэхийг шалгалаа.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

**Асуулт 1: Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх?**

**Хариулт:** Тийм

**Дүн шинжилгээ:** Хуулийн төсөлд тусгагдсан нэр томъёо нь Монгол Улсын Үндсэн хууль болон Төрийн албаны тухай хуулийн нэр томъёотой нийцэж байна.

**Асуулт 2: Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хууль тогтоомжийн зүйл, заалттай нийцэж байгаа эсэх?**

**Хариулт:** Тийм

**Дүн шинжилгээ:** Хуулийн төсөл 3 зүйлтэй бөгөөд өөр хоорондоо зөрчилгүй байгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалттай зөрчилдөөгүй байна.

**Асуулт 3: Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн заалттай давхардсан эсэх?**

**Хариулт:** Үгүй.

**Дүн шинжилгээ:** Хуулийн төслийн зүйлүүд өөр хоорондоо давхардаагүй байгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалттай давхардаагүй.

**Асуулт 4: Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх?**

**Хариулт:** Үгүй.

**Дүн шинжилгээ:** Хуулийн төслөөр зохицуулах шаардлагатай бүх харилцааг зохицуулж чадсан байна.

**Асуулт 5: Татварын хуулиас бусад тогтоолын төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх?**

**Хариулт:** Үгүй

**Асуулт 6: Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх?**

**Хариулт:** Үгүй.

**Дүн шинжилгээ:** Хуулийн төсөлд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдыг хамруулсан.

**Асуулт 7: Хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх?**

**Хариулт:** Тийм

**Дүн шинжилгээ:** Хуулийн төсөлд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдыг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, **хүйс**, эрүүл мэндийн байдал, гадаад төрх, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодлоор ялгаварлаагүй болно.

**Асуулт 8: Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?**

**Хариулт:** Үгүй.

**Асуулт 9: Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх?**

**Хариулт:** Үгүй.

## **ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

### **5.1. Баримтжуулалт**

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг ашиглалаа.

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуулиуд;
2. Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу хийсэн хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан;
3. Зардлын тооцооны судалгаа;
4. Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн баталсан хуулийн төслийн үзэл баримтлал;
5. Батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан хуулийн төсөл, танилцуулга.

## **5.2. Дүгнэлт**

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлд нийцэж байгаа бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.1 дэх хэсэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын Тавдугаар бүлэг “Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах”-т заасан шаардлагыг бүрэн хангаж байна гэж үзэж байна.

Харилцан уялдааг хангах шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан 16 асуултаас холбогдох 9 асуултыг сонгон хариулах байдлаар шалгахад “харилцан уялдаа”-г бүрэн хангаж байна.

## **5.3. Зөвлөмж**

“Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл батлагдсаны дараа Монгол Улсын Засгийн газраас мөнгөн урамшууллыг олгох нөхцөл, журмын төслийг боловсруулан батлуулах шаардлагатай байна.

## **ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ СУДАЛГАА**

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьж байна. Энэхүү хуулийн төсөлд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох зохицуулалтыг тусгасан.

### **Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын тоо**

Албан хаагчдын тоо	Ажилласан жил					Нийт дүн
	0-1 жил	2 жил	3 жил	4 жил	5 ба түүнээс дээш жил	
	297	206	232	218	1534	

2022 оны байдлаар аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт 1 жил ажилласан 297, 2 жил ажилласан 206, 3 жил ажилласан 232, 4 жил ажилласан 218, 5 ба түүнээс дээш жил ажилласан 1534 төрийн захиргааны албан хаагчид ажиллаж байна.

### **Мөнгөн урамшуулалд шаардагдах зардлын хэмжээ (тэрбум төгрөгөөр)**

№	Хугацаа	2023 он	2024 он	2025 он	2026 он	2027 он
1	Хүний тоо	1534	218	232	206	297
2	Шаардагдах зардал	5.0 тэрбум	1.0 тэрбум	1.0 тэрбум	1.0 тэрбум	1 тэрбум 200 сая

Хуулийн төсөл батлагдсанаар шаардагдах зардлын тооцоог албан хаагчдын үндсэн цалингийн дундажид үндэслэн тооцсон болно.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн хүрээнд аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгохоор тооцвол 2023 онд 1534 хүнд 5.0 тэрбум төгрөг, 2024 онд 218 хүнд 1.0 тэрбум төгрөг, 2025 онд 232 хүнд 1.0 тэрбум төгрөг, 2026 онд 206 хүнд 1.0 тэрбум төгрөг, 2027 онд 297 хүнд 1.0 тэрбум 200 сая төгрөг зарцуулахаар байна.

Нүүр хуудас > Өргөн мэдүүлэгдсэн төслүүд

## Өргөн мэдүүлэгдсэн хуулийн төслийн мэдээлэл

🏠 Дагах ☆ Хадгалах

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 8-р сарын 25 өдөр

Ulaanbaatar city

## ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 60.4 дэх хэсэг нэмсүгэй:

“60.4.Аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын тамгын газарт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн байгууллагаас нь олгоно.”

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийн “тусламж” гэсний дараа “, 60.4-т заасан мөнгөн урамшуулал” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### Төслийн файлууд

1. Өргөн мэдүүлэх -Хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл +

2. Өргөн мэдүүлэх -Үзэл баримтлал +

## **ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН САНАЛУУД**

**Монголын Үндэсний олон нийтийн телевизийн Монголын мэдээ сувгийн сурвалжлагч Э.Биндэрьяа, зураглаач Ү.Алтанбагана нарын Өвөрхангай аймгийн Бүрд, Баян-Өндөр, Сант, Баруунбаян-Улаан сумдаас бэлтгэсэн “ТОМИЛОЛТООС ИРЛЭЭ” нэвтрүүлгээр орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын цалин хөлстэй холбоотой асуудлыг онцлон хөндөв.**

*Хөдөө орон нутагт төрийн албанд ажиллах залуус ховордож, боловсон хүчний хомсдолд орох эрсдэл өндөр байна. Өвөрхангай аймагт л гэхэд сумдын төрийн албанд ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт зарладаг ч ажиллах хүч олдохгүй, нэг албан хаагч хоёроос гурван хүний ажлыг давхар хийж байна. Учир нь орон нутгийн төрийн албан хаагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх цалин авдаг, орон нутгийн нэмэгдэл авдаггүй учраас ажил хийх залуус олдохгүй, залуус төв суурин газрыг зорих нь нэмэгджээ.*

*Батзаяа Сант сумын байгаль орчныг хариуцсан мэргэжилтнээр тав дахь жилдээ ажиллаж байна. Сургуулиа төгсөөд шууд сумандаа ирж ажилласан түүний сарын цалин 480 мянган төгрөг. Гэр бүлийн хамт сумын төвд амьдрахад цалин хаанаа ч хүрдэггүй. Дээр нь сумын хэмжээнд байгаль орчн асуудал хариуцсан ганцхан мэргэжилтэнтэй учраас ажлын ачаалал их, амрах цаг байдаггүй. Таван жил ажилласан түүний цалин шатлалаараа энэ жилээс ердөө 10 хувиар нэмэгджээ. Сум орон нутагт цалин бага учраас төв суурин газарт өндөр цалин авах нь амьдралд рай илүү гэдгийг тэрбээр ярьж байлаа.*

### **Т.БАТЗАЯА /Сант сумын ЗДТГ-ын мэргэжилтэн/:**

*-Цалин үнэхээр бага. Авч байгаа цалингаа өдрөөр тооцож үзвэл өдөрт 20 гаруйхан мянган төгрөг болж байна. Цалингаасаа эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, татвараа төлөөд гар дээрээ 500 хүрэхгүй мянган төгрөг авдаг. Ер нь залуу боловсон хүчин сум орон нутагт ирж мэргэжлээрээ ажиллаад амьдралаа аваад явна гэхэд хүнд. Төгсөөд ирж байгаа залуусын цалин бага дээр нь амьдрах нөхцөл хангагдаагүй. Гадна дотноос ирсэн хүн ирээд түрээсийн байранд орно гэхэд түүнийгээ яаж төлөх вэ, хүн бүр л тодорхой хэмжээгээр зээлтэй байгаа түүнийгээ яаж төлөх билээ гэхээр цалин нь хаанаа ч хүрдэггүй.*

*Яг ийм шалтгаанаар төрийн албанд ажиллах залуус ховордож, төв суурин газрыг сонгож байна. Нээлттэй ажлын байр зарласан ч ажиллах сонирхолтой хүн олддоггүй, ирээд ажилласан ч тогтвортой ажилладаггүйгээс хүний нөөцийн хомсдолд орох эрсдэлд өндөр байгаа юм.*



### **Т.СОНИНБАЯР /Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга/:**

-Орон нутгийн хувьд төрийн захиргааны 9, босоо удирдлагатай 6 гээд төрийн жинхэнэ албан хаагч 15 хүн суманд төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлээд явж байна. Тамгын газрын 21 орон тооны төрийн жинхэнэ албан хаагч 9 хүний 6 нь төрийн захиргааны туслах түшмэл. Эдгээр албан тушаал дээр орон гарлаа гэхэд төрийн албаны ерөнхий шалгалт өгөөд тусгай шалгалтандаа тэнцээд орж ирж байгаа төрийн албан хаагчийн сарын цалин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй дүйх хэмжээний байдаг. Энэ нөхцөл байдлаас болоод сумдын Тамгын газарт хүний нөөцийн хомсдолд орох эрсдэл үүсээд байна.

*Мэдлэг боловсролтой залуус сум орон нутагтаа ирж ажиллаад нутгаа хөгжүүлэх хүсэлтэй байвч цалин бага, амьдрах орчин муу учраас залуус хөдөө орон нутагт тогтохгүй байгааг иргэд ч ярьж байна.*

-Суманд ажиллаж байгаа төрийн албан хаагч төрийн анхан шатны нэгжид ажиллаж байгаа хүмүүс. Хамгийн их ажилтай хэрнээ хамгийн бага цалин авдаг эдгээр хүмүүсийн цалин хөлсийг нэмэгдүүлэх ёстой.

Суманд төрийн албан хаагчийн хувьд Төрийн албаны хуулиар бүгдийг нь хуульчлаад заагаад өгчихсөн жишгээр л явж байна. Төрийн захиргаанд төчнөөн жил, туслах, ахлах түшмэл, дэс түшмэлээр төчнөөн жил ажилласан байх гэхчилэн шалгуур тавьдаг бөгөөд төрийн үйлчилгээний байгууллагад ажиллаж байсан хугацааг тооцдоггүй нь орон нутгийн хувьд боловсон хүчний сонголтод нөлөөлж байна.

-ТҮ 1-3- аар цалинждаг төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэх боломж байна уу. Би улсад 34 жил ажиллаж бйгаа ч сард 600 мянган төгрөгийн цалин авдаг. Энэ нь амьдралд хаанаа ч хүрэлцэхгүй байна. Насаараа төрд ажиллачихаад, хэчнээн бүсээ чангалж зүтгээд нэг хүүхэддээ ч орон сууцны урьдчилгаа хийчих боломж байдаггүй.

*Цаашид сум орон нутагт ажиллах залуусыг бодлогоор дэмжиж анхаарал тавих зайлшгүй шаардлага бий гэдгийг УИХ-ын гишүүд хэлж байна. Орон нутгийн төрийн албан хаагчдын цалинг нэмэхээс гадна амьдрах орчин, нийгмийн баталгааг хангахад анхаарах шаардлага байна.*

### **С.ЧИНЗОРИГ /УИХ-ын гишүүн/:**

-Орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалин хөлс, шаардлагатай бол ангилал зэрэглэлийг ахиулах тал дээр төр засгаас анхаарч ажиллаач гэдэг шаардлага, шүүмжлэлийг сумдад нийтлэг тавьж байна. Ялангуяа сумын Тамгын

газарт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалин бага, дээр нь орон нутагт ажилласны нэмэгдэл тэтгэмж гэж авдаггүй, орон сууцны хүрэлцээ хангамж муу зэрэг нөхцөлөөс үүдээд орон нутагт ажиллаад чадавхитай болсон залуус аймгийн төв, Улаанбаатар гээд төв суурин газар руу шилжээд явчихдаг. Ажлын байранд нь Төрийн албаны хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарладаг ч цалин хангамж муу гэдгээс үүдээд ажиллах хүн олддоггүй гэсэн зовлонг их ярьж байна. Тиймээс шаардлагатай бол Төрийн албаны тухай хуульд өөрчдөдт оруулж орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа мөнгөн тэтгэмж олгодог байх зохицуулалт хийх шаардлага байна гэж харж байгаа. Мөн нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор төрийн захиргааны албан хаагчдын ангилал зэрэглэлийг шинэчилж шатлалыг ахиулах, цалинг нэмэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага байна гэж үзэж байна.

### **Г.ГАНБОЛД /УИХ-ын гишүүн/:**

-Шинэ төгссөн залуус орон нутагт ажиллахад амьдрах орон байр байдаггүй, төрийн захиргааны албан хаагчдын цалин маш бага. Тиймээс цаашдаа төрийн албан хаагчдын ангилал зэрэглэлтэй холбоотой асуудлыг Засгийн газарт оруулж шийдүүлэх хэрэгтэй юм байна. Нөгөөтэйгүүр төрийн захиргааны албан хаагчдад бусад төрийн албан хаагчдын нэг адил удаан жилийн нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл зэрэг тэтгэмж авдаггүйг ч эргэж харах ёстой юм.

*Жил бүр Төрийн албаны ерөнхий шалгалтад 17 мянган хүн орж тэдний 5000 орчим нь нөөцөд бүртгүүлдэг. Нийт шалгалт өгч байгаа хүмүүсийн ердөө 10 хүрэхгүй хувь нь сум орон нутагт ажилладаг гэсэн судалгаа байна.*

---oOo---